ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улиастай сумын  ЗДТГ-ын  2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ЗАА-2022/35/СТА-ТШЗ**

Цахим хуудас:
www.audit.mn

Улиастай сум

2022 он

Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын
тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа
Утас: 99993365
Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Заяа
Утас:92038288
Цахим хаяг: zayag@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт ....................................................... **Error! Bookmark not defined.**
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ....................................................... 3
3. Аудитын тайлан ....................................................... 10
3.1 Ерөнхий зүйл ....................................................... 10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ....................................................... 10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ....................................................... 10
3.4 Материаллаг байдал ....................................................... 11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ....................................................... 11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ....................................................... 11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ....................................................... 12
3.8 Аудитын гол асуудал ....................................................... 12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....................................................... 12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ....................................................... 13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ....................................................... 13
4. Аудитын илрүүлэлт ....................................................... 13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ....................................................... 15

### Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс:7046-36-12

2022-02-25 № 1302/312

танай_______________-ны №_______________-т

УЛИАСТАЙ СУМЫН ЗАСАГ
ТАМГЫН ДАРГА Т.МӨНХБААТАР-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цагаанхайрхан сумын засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Цагаанхайрхан сумын засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

*Батлагдсан төсөвгүй байхад аймгийн ИТХ-аар шийдвэр гаргуулан 19,9 сая төгрөгийн техник, тоног төхөөрөмж худалдан авсан, ОНХС-ийн хөрөнгийн санхүүжилт 149,485.3 мянган төгрөгийг ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд бүртгэн авч гэрээ байгуулан ажлын бодит гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгоогүй алдаа, зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5 дахь заалтууд, ОНХС-ын үйл ажиллагааны журмын 8.1. дахь заалт, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4 дэх заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй) байна.*

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Д.БАТ-УНДРАА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| SORT_ID | Үзүүлэлт | ҮЛДЭГДЭЛ | ГҮЙЦЭТГЭЛ |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 44,307.58 | 48,630.08 |
| 60 | БАРАА МАТЕРИАЛ | 44,307.58 | 48,630.08 |
| 66 | Хангамжийн материал | 44,307.58 | 46,630.08 |
| 67 | Бичиг хэргийн материал | 2,791.34 | 2,957.64 |
| 68 | Аж ахуйн материал | 36,191.24 | 37,215.44 |
| 69 | Сэлбэг хэрэгсэл | 4,440.00 | 5,584.00 |
| 71 | Барилгын засварын материал | 885.00 | 873.00 |
| 86 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 2,041,363.13 | 1,938,857.82 |
| 106 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 2,041,363.13 | 1,938,857.82 |
| 108 | Биет хөрөнгө | 2,019,909.63 | 1,917,984.32 |
| 109 | Барилга, байгууламж | 2,266,610.55 | 2,266,610.55 |
| 110 | Хуримтлагдсан элэгдэл | - 455,891.54 | - 539,270.76 |
| 111 | Авто тээврийн хэрэгсэл | 217,393.80 | 159,899.00 |
| 112 | Хуримтлагдсан элэгдэл | - 181,432.33 | - 153,732.33 |
| 113 | Машин, тоног төхөөрөмж | 119,057.26 | 88,580.86 |
| 114 | Хуримтлагдсан элэгдэл | - 69,024.29 | - 22,271.51 |
| 115 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 47,562.33 | 48,013.33 |
| 116 | Хуримтлагдсан элэгдэл | - 42,829.54 | - 43,988.22 |
| 122 | Бусад үндсэн хөрөнгө | 151,409.00 | 151,409.00 |
| 123 | Хуримтлагдсан элэгдэл | - 32,945.60 | - 37,265.60 |
| 126 | Биет бус хөрөнгө | 21,453.50 | 20,873.50 |
| 127 | Програм хангамж | 2,862.00 | 2,862.00 |
| 128 | Хасагдуулга | - 904.50 | - 1,484.50 |
| 129 | Бусад биет бус хөрөнгө | 19,496.00 | 19,496.00 |
| 137 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 2,085,670.71 | 1,987,487.90 |
| 214 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН | 2,085,670.71 | 1,987,487.90 |
| 215 | Засгийн газрын хувь оролцоо | 2,085,670.71 | 1,987,487.90 |
| 216 | Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан | 317,322.28 | 317,322.28 |
| 217 | Өмч: -Төрийн өмч | 317,322.28 | 317,322.28 |
| 223 | Хуримтлагдсан үр дүн | 1,422,072.51 | 1,323,970.70 |
| 224 | Өмнөх үеийн үр дүн | 1,422,072.51 | 1,422,153.51 |
| 227 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 346,275.92 | 346,194.92 |
| 231 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН | 2,085,670.71 | 1,987,487.90 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| SORT_ID | ITEM_NAME | ГҮЙЦЭТГЭЛ | ГҮЙЦЭТГЭЛ |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 1,082,887.65 | 1,109,615.89 |
| 76 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 290,874.05 | 235,828.59 |
| 77 | Нийтлэг татварын бус орлого | 290,874.05 | 235,828.59 |
| 81 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 290,874.05 | 235,828.59 |
| 82 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 231,784.93 | 229,328.59 |
| 86 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 59,089.12 | 6,500.00 |
| 111 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 792,013.60 | 873,787.30 |
| 129 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 792,013.60 | 873,787.30 |
| 130 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 792,013.60 | 873,787.30 |
| 147 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II) | 1,131,677.27 | 1,207,798.70 |
| 148 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,131,677.27 | 1,098,313.30 |
| 149 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,111,945.62 | 1,072,966.26 |
| 150 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 552,036.08 | 562,264.26 |
| 151 | Цалин | 347,907.78 | 358,135.96 |
| 155 | Гэрээтийн цалин | 204,128.30 | 204,128.30 |
| 157 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 74,865.53 | 74,709.53 |
| 158 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 52,830.63 | 52,674.63 |
| 159 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 5,508.70 | 5,412.50 |
| 160 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 4,407.00 | 4,503.20 |
| 161 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 1,101.80 | 1,101.80 |
| 162 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 11,017.40 | 11,017.40 |
| 164 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 101,565.13 | 98,671.00 |
| 165 | Гэрэл цахилгааны зардал | 13,588.95 | 9,893.90 |
| 166 | Түлш, халаалтын зардал | 85,032.28 | 84,681.10 |
| 167 | Цэвэр, бохир усны зардал | 2,943.90 | 4,096.00 |
| 170 | Хангамж, бараа материалын зардал | 35,382.83 | 37,767.05 |
| 171 | Бичиг хэргийн материал | 10,633.10 | 11,806.25 |
| 172 | Тээвэр, шатахууны зардал | 14,284.40 | 14,259.16 |
| 173 | Шуудан холбоо интернетийн төлбөр | 10,465.33 | 11,701.64 |
| 185 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,920.70 | 2,039.80 |
| 189 | Урсгал засвар | 2,920.70 | 2,039.80 |
| 190 | Томилолт, зочны зардал | 252.00 | 3,535.05 |
| 192 | Дотоод томилолтын зардал | 252.00 | 3,535.05 |
| 194 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 8,179.55 | 3,327.28 |
| 195 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 6,831.45 | 1,967.18 |
| 196 | Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | 144.00 | 232.10 |
| 197 | Даатгалын үйлчилгээний төлбөр | 469.10 | 469.10 |
| 198 | Тээврийн хэрэгслийн татвар | 226.74 | 227.70 |
| 199 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 73.80 | 73.80 |
| 200 | Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс | 353.40 | 203.40 |
| 201 | Газрын төлбөр | 81.07 | 138.30 |
| 209 | Бараа үйлчилгээний бусад зардал | 336,743.81 | 290,652.30 |
| 210 | Бараа үйлчилгээний бусад зардал | 223,934.90 | 159,832.59 |
| 211 | Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал | 303.40 | 303.40 |
| 212 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 112,505.51 | 130,516.31 |
| 224 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 19,731.64 | 25,347.04 |
| 242 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 19,731.64 | 14,185.06 |
| 245 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 19,731.64 | 14,185.06 |
| 268 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II) | - 48,789.62 | - 98,182.81 |
| 288 | НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI) | - 48,789.62 | - 98,182.81 |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| | ҮЗҮҮЛЭЛТ | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 9 | 2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 317,322.28 | 346,275.92 | 1,422,072.51 | 2,085,670.71 |
| 10 | 2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 317,322.28 | 346,275.92 | 1,422,072.51 | 2,085,670.71 |
| 12 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 317,322.28 | 346,275.92 | 1,422,153.51 | 2,085,751.71 |
| 18 | 2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 317,322.28 | 346,194.92 | 1,323,970.70 | 1,987,487.90 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| SORT_ID | ITEM_NAME | ГҮЙЦЭТГЭЛ | ГҮЙЦЭТГЭЛ |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 1,023,798.53 | 1,103,115.89 |
| 77 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 231,784.93 | 229,328.59 |
| 78 | Нийтлэг татварын бус орлого | 231,784.93 | 229,328.59 |
| 82 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 231,784.93 | 229,328.59 |
| 83 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 231,784.93 | 229,328.59 |
| 110 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 792,013.60 | 873,787.30 |
| 129 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 792,013.60 | 873,787.30 |
| 130 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 792,013.60 | 873,787.30 |
| 147 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II) | 1,016,579.53 | 973,730.49 |
| 148 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,016,579.53 | 973,730.49 |
| 149 | БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 996,847.89 | 948,383.45 |
| 150 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 552,036.08 | 562,264.26 |
| 151 | Үндсэн цалин | 347,907.78 | 358,135.96 |
| 155 | Гэрээт ажлын хөлс | 204,128.30 | 204,128.30 |
| 157 | Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл | 74,865.53 | 74,367.40 |
| 158 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 52,830.63 | 52,332.50 |
| 159 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 5,508.70 | 5,412.50 |
| 160 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 4,407.00 | 4,503.20 |
| 161 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 1,101.80 | 1,101.80 |
| 162 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 11,017.40 | 11,017.40 |
| 164 | Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал | 97,521.00 | 99,671.00 |
| 165 | Гэрэл цахилгааны зардал | 9,736.84 | 9,893.90 |
| 166 | Түлш, халаалтын зардал | 85,579.94 | 85,681.10 |
| 167 | Цэвэр, бохир усны зардал | 2,204.21 | 4,096.00 |
| 170 | Хангамж, бараа материалын зардал | 34,057.93 | 37,466.90 |
| 171 | Бичиг хэрэг | 9,308.20 | 11,506.10 |
| 172 | Тээвэр, шатахуун | 14,284.40 | 14,284.40 |
| 173 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 10,465.33 | 11,676.40 |
| 181 | Нормативт зардал | 600.00 | - |
| 184 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 600.00 | - |
| 185 | Эд хогшил, урсгал засварын зардал | 3,202.70 | 2,027.80 |
| 189 | Урсгал засвар | 3,202.70 | 2,027.80 |

| | | | |
|---|---|---|---|
| 190 | Томилолт, зочны зардал | 252.00 | 3,535.05 |
| 192 | Дотоод албан томилолт | 252.00 | 3,535.05 |
| 194 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 8,179.55 | 3,327.28 |
| 195 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 6,831.45 | 1,967.18 |
| 196 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 144.00 | 232.10 |
| 197 | Даатгалын үйлчилгээ | 469.10 | 469.10 |
| 198 | Тээврийн хэрэгслийн татвар | 226.74 | 227.70 |
| 199 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 73.80 | 73.80 |
| 200 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 353.40 | 203.40 |
| 201 | Газрын төлбөр | 81.07 | 138.30 |
| 202 | Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | - | 15.70 |
| 208 | Бараа үйлчилгээний бусад зардал | 226,133.10 | 165,723.77 |
| 209 | Бараа үйлчилгээний бусад зардал | 225,829.70 | 165,420.37 |
| 210 | Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх | 303.40 | 303.40 |
| 221 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 19,731.64 | 25,347.04 |
| 225 | Бусад урсгал шилжүүлэг | - | 9,707.80 |
| 231 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 9,707.80 |
| 234 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | - | 1,454.19 |
| 237 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 1,454.19 |
| 239 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 19,731.64 | 14,185.06 |
| 242 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 19,731.64 | 14,185.06 |
| 250 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 7,219.00 | 129,385.40 |
| 251 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
| 261 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 7,219.00 | 129,385.40 |
| 262 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 7,219.00 | 129,385.40 |
| 263 | Дотоод эх үүсвэрээр | 7,219.00 | 129,385.40 |
| 267 | Бусад хөрөнгө | - | 109,485.40 |
| 275 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 7,219.00 | 19,900.00 |
| 278 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | - 7,219.00 | - 129,385.40 |
| 279 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
| 303 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
| 304 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - |
| 305 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| ҮЗҮҮЛЭЛТ | МӨР | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ |
|---|---|---|---|---|---|
| I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | | 626,648.20 | 604,116.10 | 873,787.30 | 872,333.11 |
| УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | | 626,648.20 | 604,116.10 | 873,787.30 | 872,333.11 |
| Бараа, үйлчилгээний зардал | | 587,835.90 | 576,724.42 | 864,079.50 | 862,625.31 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | | 373,653.50 | 374,215.84 | 560,386.40 | 560,386.36 |
| Үндсэн цалин | | 316,984.30 | 317,546.64 | 356,258.10 | 356,258.06 |
| Нэмэгдэл | | 56,669.20 | 56,669.20 | - | - |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | | 40,574.00 | 39,793.66 | 74,367.40 | 74,367.40 |
| Тэтгэврийн даатгал | | 25,819.70 | 25,323.24 | 52,332.50 | 52,332.50 |
| Тэтгэмжийн даатгал | | 2,950.90 | 2,894.08 | 5,412.50 | 5,412.50 |
| ҮОМШӨ ний даатгал | | 3,688.60 | 3,617.61 | 4,503.20 | 4,503.20 |
| Ажилгүйдлийн даатгал | | 737.70 | 723.52 | 1,101.80 | 1,101.80 |
| Эрүүл мэндийн даатгал | | 7,377.10 | 7,235.21 | 11,017.40 | 11,017.40 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | | 99,007.90 | 98,966.86 | 97,521.00 | 97,521.00 |
| Гэрэл цахилгаан | | 7,557.60 | 9,373.90 | 9,893.90 | 9,893.90 |
| Түлш, халаалт | | 89,681.10 | 84,364.34 | 84,681.10 | 84,681.10 |
| Цэвэр, бохир ус | | 1,769.20 | 5,228.62 | 2,946.00 | 2,946.00 |
| Хангамж, бараа материалын зардал | | 37,693.10 | 38,400.67 | 30,424.20 | 30,424.20 |
| Бичиг хэрэг | | 5,539.30 | 4,298.60 | 8,740.40 | 8,740.40 |
| Тээвэр (шатахуун) | | 8,975.80 | 24,844.43 | 14,284.40 | 14,284.40 |
| Шуудан холбоо, интернэтийн төлбөр | | 7,178.00 | 9,257.64 | 7,399.40 | 7,399.40 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс | | 16,000.00 | - | - | - |
| Эд хогшил худалдан авах | | 9,225.10 | 12,807.50 | 2,027.80 | 2,027.80 |
| Урсгал засвар | | 9,225.10 | 12,807.50 | 2,027.80 | 2,027.80 |
| Томилолт, зочны зардал | | 5,575.60 | 6,533.30 | 4,527.70 | 3,535.05 |
| Дотоод албан томилолт | | 5,575.60 | 6,533.30 | 4,527.70 | 3,535.05 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | | 15,421.70 | 1,818.94 | 3,021.60 | 2,560.10 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | | 15,421.70 | 1,818.94 | 1,200.00 | 1,200.00 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | | 6,685.00 | 4,187.65 | 91,803.40 | 91,803.40 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | | 6,600.00 | 4,187.65 | 91,500.00 | 91,500.00 |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | 85.00 | - | 303.40 | 303.40 |
| ТАТААС | | 13,780.00 | - | - | - |
| Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас | | 13,780.00 | - | - | - |
| Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас | | 13,780.00 | - | - | - |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | | 25,032.30 | 27,391.68 | 9,707.80 | 9,707.80 |
| Бусад урсгал шилжүүлэг | | 25,032.30 | 27,391.68 | 9,707.80 | 9,707.80 |
| Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | | 5,832.30 | 5,832.30 | 9,707.80 | 9,707.80 |
| Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | | 19,200.00 | 21,559.38 | - | - |
| АЖИЛЛАГСДЫН ТОО | | 54.00 | 54.00 | 54.00 | 54.00 |
| Удирдах ажилтан | | 9.00 | 9.00 | 9.00 | 9.00 |
| Гүйцэтгэх ажилтан | | 22.00 | 22.00 | 22.00 | 22.00 |
| Үйлчлэх ажилтан | | 23.00 | 23.00 | 23.00 | 23.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| ҮЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ | Дүн |
|---|---|---|---|
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - | - |
| I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | - | 105,658.14 | (105,658.14) |
| УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | - | 105,658.14 | (105,658.14) |
| Бараа, үйлчилгээний зардал | - | 105,658.14 | (105,658.14) |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | - | 1,877.90 | (1,877.90) |
| Үндсэн цалин | - | 1,877.90 | (1,877.90) |
| Нэмэгдэл | - | - | - |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | - | - | - |
| Тэтгэврийн даатгал | - | - | - |
| Тэтгэмжийн даатгал | - | - | - |
| ҮОМШӨ ний даатгал | - | - | - |
| Ажилгүйдлийн даатгал | - | - | - |
| Эрүүл мэндийн даатгал | - | - | - |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | - | 2,150.00 | (2,150.00) |
| Гэрэл цахилгаан | - | - | - |
| Түлш, халаалт | - | 1,000.00 | (1,000.00) |
| Цэвэр, бохир ус | - | 1,150.00 | (1,150.00) |
| Хангамж, бараа материалын зардал | - | 7,042.70 | (7,042.70) |
| Бичиг хэрэг | - | 2,765.70 | (2,765.70) |
| Тээвэр (шатахуун) | - | - | - |
| Шуудан холбоо, интернэтийн төлбөр | - | 4,277.00 | (4,277.00) |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс | - | - | - |
| Эд хогшил худалдан авах | - | - | - |
| Урсгал засвар | - | - | - |
| Томилолт, зочны зардал | - | - | - |
| Дотоод албан томилолт | - | - | - |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | - | 767.18 | (767.18) |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураа | - | 767.18 | (767.18) |
| Бараа үйлчилгээний бусад зардал | - | 93,820.37 | (93,820.37) |
| Бараа үйлчилгээний бусад зардал | - | 93,820.37 | (93,820.37) |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | - | - |
| ТАТААС | - | - | - |
| Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас | - | - | - |
| Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас | - | - | - |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | - | - | - |
| Бусад урсгал шилжүүлэг | - | - | - |
| Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | - | - |
| Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | - | - | - |
| ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | - | 109,485.40 | (109,485.40) |
| Дотоод эх үүсвэрээр | - | 109,485.40 | (109,485.40) |
| Тоног төхөөрөмж | - | - | - |
| Бусад хөрөнгө | - | 109,485.40 | (109,485.40) |
| ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | - | 229,328.59 | (229,328.59) |
| ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | - | - | - |
| Орон нутгийн төсвөөс | - | - | - |
| ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | - | 229,328.59 | (229,328.59) |
| Үндсан үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 229,328.59 | (229,328.59) |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - | - |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - | - |
| ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | - | - | - |
| БАЙГУУЛЛАГЫН ТОО | - | - | - |
| АЖИЛЛАГСДЫН ТОО | 54.00 | 54.00 | - |
| Удирдах ажилтан | 9.00 | 9.00 | - |
| Гүйцэтгэх ажилтан | 22.00 | 22.00 | - |
| Үйлчлэх ажилтан | 23.00 | 23.00 | - |
| СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/ | - | - | - |
| ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО | - | - | - |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Улиастай сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэл,тайлагнал, худалдан авалт, арвилан хэмнэлт зэрэгтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын ахлах аудитор Д.Оюунжаргал, ахлах аудитор Б.Дагвасүрэн нар гүйцэтгэж, хяналтыг газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа хэрэгжүүлсэн.

Улиастай сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 19-ны өдөр ирүүлсэн.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Улиастай сумын ЗДТГ нь Иргэд олон нийтийн санал, санаачлагад тулгуурлан төрийн үлчилгээг иргэн бүрт шуурхай, жигд хүртээмжтэй, үнэнч шударгаар хүргэж оновчтой бодлого, зохицуулалтаар хангах замаар сумынхаа хөгжилд дэмжлэг үзүүлэх чадварлаг, үр дүнг эрхэмлэн дээдэлсэн төрийн албыг төлөвшүүлэх зорилго тавин ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон дотоод хяналтыг хэрэгжүүлэх журам, заавар зэргийг боловсруулж мөрдөөгүй

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улиастай сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны мөнгөн гүйлгээний тайлангийн нийт орлого 11,1 сая төгрөгөөс 1 хувиар буюу 1,1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын (60-80 хувиар) буюу 7,8 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Авлага | 0.00 | 0.00 | - |
| Бараа материал | 44,307.6 | 48,630.1 | 4,322.5 |
| Үндсэн хөрөнгө | 2,041,363.1 | 1,938,857.8 | -102,505.3 |
| **Нийт хөрөнгө** | 2,085,670.7 | 1,987,487.9 | -98,182.8 |
| Өр төлбөр | 0.00 | 0.00 | - |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 2,085,670.7 | 1,987,487.9 | -98,182.8 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 2,085,670.7 | 1,987,487.9 | -98,182.8 |

Тайлант онд авлага, өр төлбөргүй ажилласан .

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 102,505.3 мянган төгрөгөөр буурсан нь элэгдлийн зардалтай холбоотой.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 98,182.8 мянган төгрөг болж буурсан нь тайлант үеийн үр дүн буурсантай холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 873,787.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 873,787.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 873,787.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 862,625.3 мянган төгрөгийг, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэжид 9,707.8 мянган төгрөгийг тус тус зарцуулж, 1,454.2 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд 2020 оны үлдэгдэлээс санхүүжсэн 18,059.8 мянган төгрөгийн, аймгийн ОНХС-аас 149,485.4 мянган төгрөгийн, замын хураамжийн орлого 1,518.0 мянган төгрөгийн, автобус үйлчилгээний орлогоор 1,413.5 мянган төгрөгийн, төсөвт байгууллагуудаас авсан өвсний үнэ 6,269.9 мянган төгрөгийн, ковидын хандив 7,815.0 мянган төгрөгийн, аймгийн Засаг даргын А/300 тоот захирамжаар 31,400.0 мянган төгрөгийн, бусад орлогоор 13,367.0 мянган төгрөгийн, нийт 229,328.6 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийн орлогыг бүрдүүлжээ.

Нэмэлт орлогоос 79,550.0 мянган төгрөгийг Жинст, Богдын гол, Өлзийт багийн замын засварт, Өлзийт багын гадна талбайн авто машины зогсоолд, Улиастай сумын гэрэлтүүлгийн сэлбэг хэрэгсэлд зарцуулж, Улиастай сумын Жинс багт “Спорт, амралт, чөлөөт цаг өнгөрүүлэх нийтийн талбай барих” ажлыг “Грэйтмаунт консалтинг ХХК”-тай гэрээ хийж 49,935,4 мянган төгрөгийг, Замын цас хайлуулах тусгай бодис худалдан авах гэрээг “Жаргалант их булаг” ХХК-тай байгуулан 20,000,0 мянган төгрөгийг олгосон, Комьютер, тоног төхөөрөмж худалдан авахад 19,900.0 мянган төгрөгийг, бараа үйлчилгээний бусад зардалд 31,573.0 мянган төгрөгийг, нийт 215143,5 мянган төгрөгийг зарцуулж, 14,185.1 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Онцолсон болон бусад асуудал гараагүй.

### 3.8 Аудитын гол асуудал

Батлагдсан төсөвгүй байхад хөрөнгө бэлтгэдэг зөрчлийг таслан зогсоох, Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43-р тогтоол, ОНХС-ын үйл ажиллагааны журмын хэрэгжилт

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

ОНХС-ын үйл ажиллагааны журмын хэрэгжилт

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг

тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 135 мэдээлэл, хугацаа хоцроосон 14 мэдээлэл, үүнээс зайлшгүй шаардлагатай 4 мэдээллийг хугацаа хоцроосон байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжиийн холбогдох заалттай бүрэн нийцэхгүй байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитаар өгөгдсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 114,7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 44,8 сая төгрөгийн зөрчилд 4 заалт бүхий зөвлөмж өгч, 69,9 сая төгрөгийн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, ажлын гүйцэтгэлд хяналт тавьж хэрэгжүүлэн гүйцэтгэлийг баримтжуулан ирүүлэх албан шаардлагыг хүргүүлэн ажиллаа.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад залрууллага хийгдээгүй

### 4.2 Төлбөрийн акт тогтоогоогүй

### 4.3 Албан шаардлага

Аудитаар 4 заалт бүхий албан шаардлагыг хүргүүлэн ажиллаа. Хэрэгжилтийг 2022 оны 6 дугаар сарын 25-ны дотор ирүүлнэ.

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал**

1.1. <u>Илрүүлэлт:</u>

- ✓ И-баримтгүй 7,220.0 мянган төгрөгийн ажил гүйлгээний төлбөрийг хийсэн

1.2. <u>Өгсөн зөвлөмж</u>:

Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2 /Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн

нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ./, НӨАТ-ын тухай хуулийн 14 дүгээр зүйийн 14.3 Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ, НББ-ын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллах И-баримтгүй ажил гүйлгээний төлбөрийг хийхгүй байх.

1.3 Илрүүлэлт:

Худалдан авсан 19,900 мянган төгрөгийн хөрөнгийг эд хариуцагч орлогод аваагүй

1.4 Өгсөн зөвлөмж:

НББ-ын тухай хуулийн 6 дугаар зүйл 6.1 Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө. гэсэн заалтын дагуу бүртгэлд тусгаж байх, эд хариуцагчын тайлан тооцоог сар бүр тогтмол хянаж хүлээн авах

## 2 Арвилан хэмнэлттэй холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

- ✓ Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй ажиллагсадын дархлааг дэмжихэд 10,800.0 мянган төгрөгийг зарцуулсан

2.2 Өгсөн зөвлөмж:

- ✓ Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, төсвийн зарцуулалтад тавих дотоод хяналтыг сайжруулах;

2.3 Илрүүлэлт:

Төсөвт байгууллагуудаас өвс, өвсний үнэнд 6,969.9 мянган төгрөгийг бүрдүүлэн зарцуулсан

2.4 Өгсөн зөвлөмж:

- ✓ Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл_6.2.2. жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх гэсэн заалтыг мөрдөн ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1. | Асгат сумын ЗДТГ | 5 | 114,7 | | | | | 1 | 69,9 | 4 | 44,8 |